

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн  
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/324/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он	Уваа Уул Аудит ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа Утас: 99108763 Цахим хаяг: uua.audit@gmail.com Аудитор: Ц.Саранцэцэг Утас: 93040983 Цахим: sarantsetsegts428@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
5. АУДИТЫН ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23 № 82  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ  
ДҮҮРГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
Н.АРИУНАА ТАНАА

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл



үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 96.7 хувийн хэрэгжилттэйгээр гүйцэтгэн, тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>99,914,664,810.01</b>	<b>90,360,544,943.83</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>15,236,145,112.12</b>	<b>21,366,392,889.43</b>
<b>31100</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>15,236,145,112.12</b>	<b>21,366,392,889.43</b>
<b>31200</b>	<b>Төгрөг</b>	<b>15,236,145,112.12</b>	<b>21,366,392,889.43</b>
31211	Төрийн сангийн харилцах	-	105,736,810.72
31213	Арилжааны банк дахь харилцах	15,231,809,012.12	21,258,569,978.71
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	4,336,100.00	2,086,100.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>84,639,850,524.39</b>	<b>68,953,481,358.40</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	35,254,988,593.40	38,483,447,486.24
33300	Татаас, санхүүжилтийн авлага	49,228,389,201.81	29,991,110,545.05
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>156,472,729.18</b>	<b>478,923,327.11</b>
33510	Байгууллагаас авах авлага	156,472,729.18	478,923,327.11
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>38,669,173.50</b>	<b>40,670,696.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>38,669,173.50</b>	<b>40,670,696.00</b>
35410	Бичиг хэргийн материал	5,232,202.00	2,368,300.00
35420	Аж ахуйн материал	13,908,443.00	16,005,183.00
35430	Сэлбэг хэрэгсэл	18,341,703.00	21,138,203.00
35470	Бусад хангамжийн материал	1,186,825.50	1,159,010.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,245,731,413.20</b>	<b>2,171,257,819.30</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,245,731,413.20</b>	<b>2,171,257,819.30</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,218,542,733.20</b>	<b>2,144,069,139.30</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,259,969,856.00	2,259,969,856.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(180,768,985.28)	(219,987,791.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,864,000.00	9,864,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,466,000.00)	(4,932,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	120,215,135.68	113,315,535.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,776,927.16)	(46,175,956.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	131,312,010.00	123,406,260.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(86,806,356.04)	(91,390,765.02)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>27,188,680.00</b>	<b>27,188,680.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	27,188,680.00	27,188,680.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>102,160,396,223.21</b>	<b>92,531,802,763.13</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,354,972,929.97</b>	<b>6,808,199,957.33</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,354,972,929.97</b>	<b>6,808,199,957.33</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>226,497,485.43</b>	<b>717,847,474.96</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	226,497,485.43	717,847,474.96
	Урьдчилж орсон орлого	2,128,475,444.54	6,090,352,482.37
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	2,128,475,444.54	6,090,352,482.37
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>99,805,423,293.24</b>	<b>85,723,602,805.80</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>629,969,700.64</b>	<b>629,969,700.64</b>

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	300,550,663.51	300,550,663.51
51200	Хуримтлагдсан үр дүн	99,175,453,592.60	85,093,633,105.16
51210	Өмнөх үеийн үр дүн	99,175,453,592.60	98,945,919,150.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	(13,852,286,045.60)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	329,419,037.13	329,419,037.13
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>102,160,396,223.21</b>	<b>92,531,802,763.13</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>493,592,206,895.54</b>	<b>657,009,742,578.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>465,318,199,301.52</b>	<b>622,152,000,389.04</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>465,318,199,301.52</b>	<b>622,152,000,389.04</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	311,794,498,072.85	415,239,525,688.47
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	33,574,092,763.86	44,731,901,871.29
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	38,573,943,724.60	53,631,588,856.78
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	6,804,877,608.12	9,048,836,065.06
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	74,570,787,132.09	99,500,147,907.44
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>407,045,207.02</b>	<b>1,074,536,846.46</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>407,045,207.02</b>	<b>1,074,536,846.46</b>
120002	Хүүгийн орлого	2,075,273.46	298,227,131.00
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>98,662,431.40</b>	<b>242,695,225.46</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	98,256,431.40	240,109,664.75
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	406,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	2,585,560.71
120009	Бусад орлого	306,307,502.16	533,614,490.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>27,866,962,387.00</b>	<b>33,783,205,343.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төсвөөс</b>	<b>26,617,708,722.00</b>	<b>32,232,951,763.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	26,617,708,722.00	32,232,951,763.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>125,332,065.00</b>	<b>6,466,880.00</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	125,332,065.00	6,466,880.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,123,921,600.00</b>	<b>1,543,786,700.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,099,995,400.00	1,543,786,700.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,926,200.00	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>541,350,938,707.91</b>	<b>670,862,028,624.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>541,350,938,707.91</b>	<b>670,862,028,624.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,126,566,477.56</b>	<b>1,392,174,461.26</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>839,137,702.14</b>	<b>1,057,873,786.11</b>
210101	Үндсэн цалин	570,596,579.91	594,492,863.33
210102	Нэмэгдэл	109,544,957.48	189,421,338.48
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	96,746,743.36	133,026,530.42
210104	Урамшуулал	62,249,421.39	140,933,053.88
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>111,150,072.28</b>	<b>135,802,450.79</b>
210201	Тэтгэврийн даатгал	77,103,374.79	95,584,503.90
210202	Тэтгэмжийн даатгал	9,207,559.83	11,244,171.83



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	7,366,008.50	8,593,234.87
210204	Ажилгүйдлийн даатгал	1,785,460.48	1,891,430.67
210205	Эрүүл мэндийн даатгал	15,687,668.68	18,489,109.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,634,428.67</b>	<b>37,782,042.35</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,889,588.00	14,319,722.79
210302	Түлш, халаалт	20,054,911.67	19,633,929.30
210303	Цэвэр, бохир ус	3,689,929.00	3,828,390.26
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,195,903.36</b>	<b>46,007,165.40</b>
210401	Бичиг хэрэг	10,639,864.00	23,340,132.00
210402	Тээвэр, шатахуун	3,355,800.00	948,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,420,825.36	4,582,607.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,110,000.00	1,233,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,669,414.00	15,249,500.00
210408	Бараа материал акталсны зардал	-	653,425.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,643,500.00</b>	<b>13,750,000.00</b>
210604	Урсгал засвар	20,643,500.00	13,750,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>26,791,332.00</b>	<b>21,762,062.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,797,451.00	4,016,178.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,900,000.00	7,340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	292,100.00	350,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	81,984.00
210807	Газрын төлбөр	684,202.00	110,250.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,929,890.00	8,153,480.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,127,705.00	1,710,070.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>72,013,539.11</b>	<b>79,196,954.61</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,561,000.00	2,630,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	69,452,539.11	76,566,954.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>540,224,372,230.35</b>	<b>669,469,854,162.84</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>173,841,901,812.00</b>	<b>209,244,691,970.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	173,804,359,590.00	209,176,663,125.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,281,022.00	11,040,009.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,261,200.00	56,988,836.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>366,382,470,418.35</b>	<b>460,225,162,192.84</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	366,382,470,418.35	460,225,162,192.84
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>(47,758,731,812.37)</b>	<b>(13,852,286,045.60)</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(47,758,731,812.37)</b>	<b>(13,852,286,045.60)</b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>540,643,040,800.39</b>	<b>676,998,766,324.34</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>456,859,080,074.41</b>	<b>622,268,580,706.07</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>456,859,080,074.41</b>	<b>622,268,580,706.07</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	306,083,443,893.70	415,309,239,052.87
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	33,004,230,346.63	44,723,933,783.80
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	37,876,502,494.30	53,627,532,040.51
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	6,694,352,547.43	9,079,668,363.20
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	73,200,550,792.35	99,528,207,465.69
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>439,629,825.98</b>	<b>804,467,118.27</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>439,629,825.98</b>	<b>804,467,118.27</b>
120002	Хүүгийн орлого	2,075,273.46	298,177,048.28
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>437,554,552.52</b>	<b>506,290,069.99</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	437,148,552.52	506,290,069.99
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	406,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>83,344,330,900.00</b>	<b>53,925,718,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>82,170,421,600.00</b>	<b>52,381,931,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	82,170,421,600.00	52,381,931,800.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>49,987,700.00</b>	<b>-</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,987,700.00	-
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,123,921,600.00</b>	<b>1,543,786,700.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,099,995,400.00	1,543,786,700.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,926,200.00	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>541,919,726,773.12</b>	<b>670,868,518,547.03</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>541,919,726,773.12</b>	<b>670,868,518,547.03</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,056,917,922.55</b>	<b>1,310,649,949.15</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>841,110,626.14</b>	<b>1,057,873,786.11</b>
210101	Үндсэн цалин	572,569,503.91	594,492,863.33
210102	Нэмэгдэл	109,544,957.48	189,421,338.48
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	96,746,743.36	133,026,530.42
210104	Урамшуулал	62,249,421.39	140,933,053.88
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>110,341,028.38</b>	<b>135,802,450.79</b>
210201	Тэтгэврийн даатгал	76,294,330.89	95,584,503.90
210202	Тэтгэмжийн даатгал	9,207,559.83	11,244,171.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,366,008.50	8,593,234.87
210204	Ажилгүйдлийн даатгал	1,785,460.48	1,891,430.67
210205	Эрүүл мэндийн даатгал	15,687,668.68	18,489,109.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,634,428.67</b>	<b>37,782,042.35</b>



Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	8,889,588.00	14,319,722.79
210302	Түлш, халаалт	20,054,911.67	19,633,929.30
210303	Цэвэр, бохир ус	3,689,929.00	3,828,390.26
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,457,212.36</b>	<b>39,213,177.90</b>
210401	Бичиг хэрэг	11,248,630.00	15,595,030.00
210402	Тээвэр, шатахуун	3,355,800.00	948,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,420,825.36	4,582,607.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,110,000.00	1,233,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,321,957.00	16,854,040.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,430,000.00</b>	<b>16,546,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,786,500.00	2,796,500.00
210604	Урсгал засвар	20,643,500.00	13,750,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,383,627.00</b>	<b>20,801,992.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,797,451.00	4,766,178.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,620,000.00	7,340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	292,100.00	350,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,984.00	81,984.00
210807	Газрын төлбөр	684,202.00	110,250.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,929,890.00	8,153,480.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,561,000.00</b>	<b>2,630,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,561,000.00	2,630,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>540,862,808,850.57</b>	<b>669,557,868,597.88</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>174,480,338,432.22</b>	<b>209,332,706,405.04</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	173,886,632,852.01	208,902,997,517.90
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,281,022.00	11,040,009.00
213205	Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, урамшуулал	556,163,358.21	361,680,042.14
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,261,200.00	56,988,836.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>366,382,470,418.35</b>	<b>460,225,162,192.84</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	366,382,470,418.35	460,225,162,192.84
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>(1,276,685,972.73)</b>	<b>6,130,247,777.31</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(1,276,685,972.73)</b>	<b>6,130,247,777.31</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,512,831,084.85	15,236,145,112.12
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,236,145,112.12	21,366,392,889.43



## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин Үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>273,361,983.51</b>	<b>3,000,373.89</b>	<b>26,558,532,081.68</b>	<b>26,834,894,439.08</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(99,949,317.16)	(99,949,317.16)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	26,458,582,764.52	26,458,582,764.52
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	27,188,680.00	-	-	27,188,680.00
Тайлант үеийн үр дүн	-	-	97,302,597,840.79	97,302,597,840.79
<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>300,550,663.51</b>	<b>329,419,037.13</b>	<b>123,761,180,605.31</b>	<b>124,391,150,305.95</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(229,534,441.84)	(229,534,441.84)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	300,550,663.51	329,419,037.13	98,945,919,150.76	99,575,888,851.40
Тайлант үеийн үр дүн	-	-	(13,852,286,045.60)	(13,852,286,045.60)
<b>2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>300,550,663.51</b>	<b>329,419,037.13</b>	<b>85,093,633,105.16</b>	<b>85,723,602,805.80</b>



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		15,236,145,112.12		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	215,268,857,500.00	210,279,426,312.05	4,989,431,187.95	97.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	215,268,857,500.00	210,279,426,312.05	4,989,431,187.95	97.7
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,473,477,400.00	1,310,649,949.15	162,827,450.85	88.9
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,186,809,500.00	1,057,873,786.11	128,935,713.89	89.1
210101	Үндсэн цалин	627,679,800.00	594,492,863.33	33,186,936.67	94.7
210102	Нэмэгдэл цалин	209,764,700.00	189,421,338.48	20,343,361.52	90.3
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	190,990,800.00	133,026,530.42	57,964,269.58	69.7
210104	Урамшуулал	158,374,200.00	140,933,053.88	17,441,146.12	89.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,413,700.00	135,802,450.79	13,611,249.21	90.9
210201	Тэтгэврийн даатгал	101,601,200.00	95,584,503.90	6,016,696.10	94.1
210202	Тэтгэмжийн даатгал	11,953,100.00	11,244,171.83	708,928.17	94.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,562,500.00	8,593,234.87	969,265.13	89.9
210204	Ажилгүйдлийн даатгал	2,390,700.00	1,891,430.67	499,269.33	79.1
210205	Эрүүл мэндийн даатгал	23,906,200.00	18,489,109.52	5,417,090.48	77.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,388,100.00	37,782,042.35	9,606,057.65	79.7
210301	Гэрэл, цахилгаан	17,809,700.00	14,319,722.79	3,489,977.21	80.4
210302	Түлш, халаалт	23,844,000.00	19,633,929.30	4,210,070.70	82.3
210303	Цэвэр, бохир ус	5,734,400.00	3,828,390.26	1,906,009.74	66.8
2104	Хангамж, бараа материалын зардал	40,024,700.00	39,213,177.90	811,522.10	98.0
210401	Бичиг хэрэг	15,600,000.00	15,595,030.00	4,970.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	1,354,400.00	948,500.00	405,900.00	70.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,977,100.00	4,582,607.90	394,492.10	92.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,235,000.00	1,233,000.00	2,000.00	99.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,858,200.00	16,854,040.00	4,160.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,561,000.00	16,546,500.00	14,500.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,811,000.00	2,796,500.00	14,500.00	99.5
210604	Урсгал засвар	13,750,000.00	13,750,000.00	-	100.0
	Томилолт, зочны зардал	1,270,000.00	-	1,270,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,270,000.00	-	1,270,000.00	-



**Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,160,400.00</b>	<b>20,801,992.00</b>	<b>8,358,408.00</b>	<b>71.3</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,000,000.00	4,766,178.00	233,822.00	95.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,650,000.00	7,340,000.00	310,000.00	95.9
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	350,100.00	149,900.00	70.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	81,984.00	118,016.00	41.0
210807	Газрын төлбөр	350,000.00	110,250.00	239,750.00	31.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,460,400.00	8,153,480.00	7,306,920.00	52.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,850,000.00</b>	<b>2,630,000.00</b>	<b>220,000.00</b>	<b>92.3</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,850,000.00	2,630,000.00	220,000.00	92.3
<b>213</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>213,795,380,100.00</b>	<b>208,968,776,362.90</b>	<b>4,826,603,737.10</b>	<b>97.7</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	213,709,752,800.00	208,902,997,517.90	4,806,755,282.10	97.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,822,800.00	8,790,009.00	32,791.00	99.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	76,804,500.00	56,988,836.00	19,815,664.00	74.2
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>215,268,857,500.00</b>	<b>575,741,409,035.27</b>	<b>360,472,551,535.27</b>	<b>267.5</b>
<b>31</b>	<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>52,381,931,800.00</b>	<b>52,381,931,800.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	52,381,931,800.00	52,381,931,800.00	-	100.0
<b>34</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>162,886,925,700.00</b>	<b>523,014,701,087.10</b>	<b>360,127,775,387.10</b>	<b>321.1</b>
340001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	162,886,925,700.00	523,014,701,087.10	360,127,775,387.10	321.1
<b>35</b>	<b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>	<b>-</b>	<b>344,776,148.17</b>	<b>344,776,148.17</b>	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	344,776,148.17	344,776,148.17	
<b>IV</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>21,366,392,889.43</b>	<b>21,366,392,889.43</b>	
	<b>АЖИЛЛАГСАД БҮГД</b>	<b>63</b>	<b>49</b>	<b>14.00</b>	<b>77.8</b>
	Удирдах ажилтан	1	1	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	54	42	12.00	77.8
	Үйлчлэх ажилтан	8	6	2.00	75.0



### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 2<sup>1</sup> дүгээр зүйлийн 2<sup>1.1.2</sup> “ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох үйл ажиллагааг эрхлэх” гэж тодорхойлсон.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлж тайлант онд Нийгмийн даатгалын тухай багц хуулийг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын бүртгэл мэдээллийн чанарыг сайжруулах, үйлчилгээний стандарт, чанар хүртээмж, үйлчилгээний соёл, сахилга хариуцлага, үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтын үр дүнг дээшлүүлэх, байцаагч ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, хариуцлагыг чангатгах, иргэдийг нийгмийн даатгалд даатгах, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг найдвартай түргэн шуурхай хүргэх, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант оны онцлог үйл явдлууд:

- “Дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны систем”-ийг нэвтрүүлсэн;
- Ажил олгогчдын нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулсан;
- ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн, Олон улсын стандартын гэрчилгээг авсан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаандаа Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөн ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Тухайлбал:

- Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2023 оны “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай” 213 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2023 оны “Засгийн газрын хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол “Журам батлах тухай” төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам;
- Засгийн газрын 2023 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 10 хувиар тус тус нэмэгдүүлсэн;
- Засгийн газрын 2023 оны 200 дугаар тогтоолоор Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг шинэчлэн баталсан;



- Засгийн газрын 2023 оны “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 237 дугаар тогтоолоор халамжийн тэтгэврийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод аудитын газраас санхүүгийн үндсэн үйл ажиллагаа болон сангуудад дотоод аудит хийгээгүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2018 онд хэвлүүлсэн нэгдсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,628,593.5 мянган төгрөг буюу 9.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	15,236,145.1	21,366,392.9	6,130,247.8
Авлага	84,639,850.5	68,953,481.4	(15,686,369.2)
Бараа материал	38,669.2	40,670.7	2,001.5
Үндсэн хөрөнгө	2,245,731.4	2,171,257.8	(74,473.6)
Нийт хөрөнгө	102,160,396.2	92,531,802.8	(9,628,593.5)
Өглөг	226,497.5	717,847.5	491,350.0
Урьдчилж орсон орлого	2,128,475.4	6,090,352.5	3,961,877.1
Засгийн газрын оролцоо /Эздийн емч/	99,805,423.3	85,723,602.8	(14,081,820.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	102,160,396.2	92,531,802.8	(9,628,593.5)

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь авлага, үнсэн хөрөнгө, дансны өглөг, урьдчилж орсон орлогын данс байна. Үүнд:



- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 21,366,392.9 мянган төгрөг болж 6,130,247.8 мянган төгрөгөөр өссөн нь ажил олгогч, сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэврийн сан тус тус нэмэгдсэнтэй холбоотой;
- Авлага дансны үлдэгдэл 68,953,481.4 мянган төгрөг болж 15,686,369.2 мянган төгрөгөөр буурсан нь авлага барагдуулалтын төлөвлөгөөг 32%-иар буюу 149,282,800.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлснээс шалтгаалсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,171,257.8 мянган төгрөг болж 74,473.6 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3,141.3 мянга, үнэ шинэчилсэн тогтоосон 2,043.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, хөрөнгө акталж устгасан 9,773.0 мянга, үнэ шинэчилж данснаас хассан 10,217.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдаж, тайлант хугацааны 59,668.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлаас тус тус шалтгаалсан;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 717,847.5 мянган төгрөг болж 491,350.0 мянган төгрөгөөр өссөн нь 60 хоногоос дээш авлагатай ажил олгогч нарын ажилчдын жирэмсэн амаржсан, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг өглөгөөр бүртгэсэнтэй холбоотой,
- Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 6,090,352.5 мянган төгрөг болж 3,961,877.1 мянган төгрөгөөр өссөн нь ажил олгогч, сайн дурын даатгуулагчид нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлснөөс шалтгаалсан,
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 85,723,602.8 мянган төгрөг болж 14,081,820.5 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын хэлтэс, сангийн тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн төсөлд сангийн орлогыг 377,285,431.6 мянган төгрөг, сангийн зарлага 214,285,235.1 мянган төгрөг, хэлтсийн үйл ажиллагааны зардлыг 1,871,881.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас сангийн орлогыг 215,268.9 мянган төгрөг байхаар, үйл ажиллагааны зардлыг 1,543,786.7 мянган төгрөг байхаар тус тус баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг нийгмийн даатгалын сангаас 1,543,786.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас 1,543,786.7 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 1,368,417.7 мянган төгрөгийг зарцуулж, 175,369.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,368,417.7 мянган төгрөг буюу 88.6 хувьтай байгаа нь цалин хөлстэй холбоотой зардал 142,546.9 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 9,606.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 220.0 мянга, шуудан, холбоо, интернэтийн зардлыг 394.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71901	Нийгмийн даатгал	1,543,786.7	1,368,417.7	175,369.0	88.6
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,385,290.5	1,231,096.9	154,193.6	88.9



1.2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	7,425.0	7,279.8	145.2	98
1.3	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	3,000.0	2,926.2	73.8	97.5
1.4	80213	Өмгөөлөл, хуулийн зөвлөх	1,100.0	1,090.0	10.0	99.1
1.5	80219	Харуул, хамгаалалтын зардал	150.0	0.0	150.0	-
1.6	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	61,193.9	60,246.0	947.9	98.5
1.7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшуулал	76,804.5	56,988.8	19,815.7	74.2
1.8	80813	Хуульд заасан үндэслэлээр алба	2,800.0	2,790.0	10.0	99.6
1.9	80820	Бусад тусламж, дэмжлэг	6,022.8	6,000.0	22.8	99.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, журмын дагуу хөтлөх, хөрөнгө, авлагын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Уваа уул аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг аудиторын туслах Сампилмаа нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг захирал Ч.Мөнхтуяа, Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 55 дугаар албан бичгээр Уваа уул Аудит ХХК-д ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 541,350,938.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,413,509.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын цахилгаан халаалтын температурыг ажлын бус цагаар багасгаж тог цахилгааныг хэмнэх зохицуулалт хийж ажилласнаар тогтмол зардлаас 9,606.1 мянган төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 3 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн байршуулбал зохих 1,590,957,257.7 мянган төгрөгийн 342 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас орлогын 702,817,763.4 мянган төгрөгийн 24, зарлагын 888,139,494.3 мянган төгрөгийн 24, бусад нийт 1,590,957,257.7 мянган төгрөгийн 342 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль эрхийн актын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 22,016.8 мянган төгрөгийн 3 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 22,016.8 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулсан байна. Хэрэгжүүлээгүй 1 зөрчлийг тайлант оны аудитын тайланд тусгасан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 104,282.2 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт-3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	<i>Мянган төгрөг/</i>						
	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	104,282.2	3	104,282.2			100
Нийт дүн	3	104,282.2	3	104,282.2			100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нийгмийн даатгалын сангуудын программын сайжруулалтыг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 2 зөрчил илэрч зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. *Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал*

Илрүүлэлт-1: Газар эзэмших эрхийн хэмжих нэгжийг данс бүртгэлд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5. "хэмжигдэхүйц байх", 20 дугаар зүйлийн 20.2.3. "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших эрхийг биет бус хөрөнгийн дансанд хэмжих нэгжийг зөв илэрхийлэн бүртгэх.

#### 2. *Авлагын данстай холбоотой асуудал*

Илрүүлэлт-2: Насжилт өндөртэй авлагыг шийдвэрлүүлж, барагдуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалттай нийцээгүй

Өгсөн зөвлөмж: Насжилт өндөртэй авлагыг бүүруулах ажлыг зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Насжилт өндөртэй авлагыг шийдвэрлүүлж, барагдуулаагүй	1	-					1					
2	Газар эзэмших эрхийн хэмжих нэгжийг данс бүртгэлд тусгаагүй	1	-					1	-				
	Дүн	2						2					



ААББ Б АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

АУДИТЫН КОД  
АУДИТЫН КЭР  
Тайлант хугацаа

НТАГ 2024/3/4/НА СТА 11/3  
Саяагчийн гэрлэлтийн бүтэц  
2023-01-01-2023-12-31

Эргэлтэй АГАДУТ-н түвшинд хэрэгжүүлэх түүхийн сорилтын үр дүнг үнэлж шийдвэрлэх

А/д	Нөхцөл байдлыг АГАДУТ-н түвшинд хэрэгжүүлэх түүхийн сорилтын үр дүнг үнэлж шийдвэрлэх	А/д	АГАДУТ-н түвшинд хэрэгжүүлэх түүхийн сорилтын үр дүнг үнэлж шийдвэрлэх	Үр дүгээр	Тухайн үр дүнг үнэлж шийдвэрлэх	Мөнгөн дүн	Материаллаг ашиг	Шөлүүр		Аудитын байгууллагын гэрлэлтийн үндэс	Аудитын байгууллагын санхүүгийн тайлбар	Аудитын байгууллагын гэрлэлтийн үндэс	Аудитын байгууллагын гэрлэлтийн үндэс
								Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Өмнөх оны аудитын төлөвлөгөөнийг дахин үнэлж шийдвэрлэх	1	Өмнөх оны аудитын төлөвлөгөөнийг дахин үнэлж шийдвэрлэх	Аудитын төлөвлөгөөнийг дахин үнэлж шийдвэрлэх	Зөрчилтэй	0	материаллаг ашиггүй	Ур дүгээр 7.1.8-ийн үндэстэй нийцэхгүй	Ур дүгээр 7.1.8-ийн үндэстэй нийцэхгүй	Зөвлөмж	2024 оны нийгмийн даатгалын шимтгэлийн өр аавыг байцаж харуулах байдлаар хуулийн мэдээлэлтэй орон тоо шинээр нэмэгдсэн байдлаар тул цаашад шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албад шилжүүлсэн өмчлөгчийн шимтгэлийн өсөлтийг харгалзан үзжээ	Саяагчийн гэрлэлтийн үндэс	Зөвлөмж
2	Давсны үнцэгдэл	2	Давсны үнцэгдэл	Галар эзэмшигчдийн өр аавыг харгалзан үзжээ	Зөрчилтэй	0	материаллаг ашиггүй	Ур дүгээр 20.2.5-ийн үндэстэй нийцэхгүй	Ур дүгээр 20.2.5-ийн үндэстэй нийцэхгүй	Зөвлөмж	Чөлөөтэй дүүргийн Прокурорын газраар шалган үнэлж шийдвэрлэх тухай хууль, Зөрчилтэй шийдвэрлэх тухай хуулийн талаар хууль эрх зүйн зөвлөхөө мэдээлэл өгч үндэстэй нийцэхгүй харуулах ажиллагааг төлөвлөж байна	Саяагчийн гэрлэлтийн үндэс	Зөвлөмж
3	Бусад үнцэгдэл	3	Бусад үнцэгдэл	Галар эзэмшигчдийн өр аавыг харгалзан үзжээ	Зөрчилтэй	0	материаллаг ашиггүй	Ур дүгээр 20.2.5-ийн үндэстэй нийцэхгүй	Ур дүгээр 20.2.5-ийн үндэстэй нийцэхгүй	Зөвлөмж	Программын түвшинд холбогдох гэрээнд өгбөр бичгээр захирагчид шийдвэрлүүлнэ	Саяагчийн гэрлэлтийн үндэс	Зөвлөмж

Тайланг зохиогч  
Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын кассын дарга  
Ерөнхий нягтлан баригч  
Т.Оюунсүх  
Т.Оюунсүх

Огноо: 2024.02.14  
Огноо: 2024.02.14

